



ТӨВ АЙМГИЙН  
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/475

Зуунмод

Сумын Засаг даргаас олгох шагналын  
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, Засаг даргын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.“Зуунмод сумын Засаг даргаас олгох шагналын журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Сумын Засаг даргын шагнал гардуулах арга хэмжээг тухай бүр чанарын өндөр түвшинд зохион байгуулан ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3.Шагналд зарцуулагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас олгохыг Санхүүгийн албаны дарга (Н.Цанлигсүрэн), Нягтлан бодогч (С.Намшир) нарт зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Зуунмод сумын Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/38 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



САРАНГЭРЭЛ

Сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 1475 дугаар захирамжийн хавсралт



## **ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГААС ОЛГОХ ШАГНАЛЫН ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Сумын хөгжил цэцэглэлт, иргэдийн сайн сайхны төлөөх үйлсэд эрхэлсэн ажил, эрдэм мэдлэг, авьяас чадвараараа дайчлан тогтвортой, амжилттай ажиллаж байгаа орон нутгийн бүх шатны байгууллагын ажилтнууд, дотоод, гадаадын иргэдийг урамшуулж, алдаршуулах, шагнал олгохтой холбогдсон асуудлыг энэхүү журмаар зохицуулна.

### **Хоёр. Сумын Засаг даргаас олгох шагналын төрөл**

- 2.1. Сумын Засаг дарга бөгөөд Хотын захирагчийн “Хүндэт жуух” бичиг
- 2.2. Сумын “Хөдөлмөрийн аварга” /Өргөмжлөл, энгэрийн тэмдэг/
- 2.3. “Оны шилдэг байгууллага” /Төрийн болон төрийн бус байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар /
- 2.4. “Оны шилдэг айл өрх” /6-н багийн айл өрхөөс/

### **Гурав. Шагналд нэр дэвшигчдэд тавигдах болзол, шаардлага**

3.1. Эрхэлсэн ажилдаа мэргэжлийн өндөр ур чадвар гаргаж, тогтвортой амжилт үзүүлж, хамт олноо манлайлан эдийн засаг, хөдөө аж ахуй, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд 3-аас доошгүй жил ажиллаж хөдөлмөрийн амжилт үзүүлсэн хүмүүсийг сумын Засаг даргын “Хүндэт жуух” бичгээр шагнана.

3.2. Сүүлийн 3 жилийн ажлын үр дүнгээр сумын хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулан, сум орон нутгийн нэр хүндийг улс, аймгийн хэмжээнд гаргаж, байгууллагын аваргаар шалгарч байсан ажилтан, албан хаагчийг сумын “Хөдөлмөрийн аварга”-аар шалгаруулан өргөмжлөл, энгэрийн тэмдэг олгоно.

3.3. Орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд албан хаагчдын идэвхийг өрнүүлж тодорхой асуудлыг амжилттай шийдвэрлэсэн, Нийгмийн хариуцлагын гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж ажилласан хамт олныг “Оны шилдэг байгууллага”, иргэний үүргээ хангалттай сайн биелүүлсэн өрхийг “Оны шилдэг айл өрх”-өөр тус тус шалгаруулан шагнана.

3.3.1. Энэхүү шагналыг олгохдоо тухайн жилийн онцлогийг харгалзан тусгайлан гаргасан удирдамж, үзүүлэлтийн дагуу шалгаруулна.

3.3.2. “Оны шилдэг байгууллага”, “Оны шилдэг айл өрх” шалгаруулах ажлыг захирагчийн ажлын алба, Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулна.

3.3.3. Энэхүү журмын 3.1-т заасан шагналыг зөвхөн нэг удаа олгоно.

**Дөрөв.Сумын “Хөдөлмөрийн аварга”-д нэр дэвших номинаци**

№	“Хөдөлмөрийн аварга”-ын номинаци	Шалгаруулах номинацийн тоо	Тухайн номинацид хамрагдах мэргэжлийн төрөл, байгууллагын чиглэл
1	Төрийн түшээ	1	Улс төрийн болон төрийн захиргааны албаны удирдах албан тушаалтан
2	Төрийн захиргааны албан хаагч	2	Төрийн захиргааны албан хаагч
3	Менежер	1	Байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрийн газрын дарга, захирал, эрхлэгч нар
4	Хууль, хяналтын байгууллагын ажилтан	2	Тусгай чиг үүргийн байгууллагын ажилтнууд
5	Санхүү, эдийн засгийн ажилтан	1	Эдийн засаг, санхүүгийн салбарын ажилтнууд
6	Эрчим хүчний салбарын ажилтан	2	Цахилгаан болон дулааны эрчим хүчний салбарын ажилтнууд
7	Мэдээлэл холбооны ажилтан	2	Мэдээлэл технологи, харилцаа холбооны /телевиз, сонины сэтгүүлч, сурвалжлагч, зураглаач, интернет мэдээлэл/ ажилтнууд
8	Ахуй үйлчилгээний ажилтан	1	Ахуй үйлчилгээний салбарын ажилтнууд
9	Хүнсчин-тогооч	1	Хүнсний үйлдвэлэлийн салбарын ажилтнууд /тогооч, бэлтгэгч, зөөгч/
10	Зам, тээврийн салбарын ажилтан	2	Инженер, жолооч, замчин, механикч
11	Хөдөө аж ахуйн ажилтан	2	Хөдөө аж ахуйн салбарын ажилтнууд /малчин, фермер, тариаланч гэх мэт/
12	Үйлдвэрлэгч баялаг бүтээгч	1	Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, худалдагч, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч
13	Хүнс худалдаа үйлчилгээний ажилтан	2	
14	Байгаль орчны салбарын ажилтан	1	Байгаль орчны салбарын ажилтнууд
15	Багш	2	Ерөнхий боловсрол, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн ажилтнууд Сургуулийн өмнөх боловсролын ажилтнууд
16	Эмч	1	Эрүүл мэндийн салбарын ажилтнууд
17	Эрүүл мэндийн ажилтан	1	Эрүүл мэндийн салбарын тусгай мэргэжилтэн, сувилагч, асрагч



18	Тамирчин	1	Биеийн тамир, спортын газрын салбарын ажилтнууд
19	Соёл урлагийн ажигтан	1	Соёл урлагийн салбарын ажилтнууд
20	Үйлчилгээний ажилтан	2	Бүх салбарын төрийн үйлчилгээний ажилтнууд
21	Барилгын ажилтан	1	Барилга, байгууламжийн салбарын ажилтнууд
22	Шилдэг байгууллага	1	Төрийн болон төрийн бус байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар

### **Тав. Шагналд нэр дэвшүүлэх, шийдвэрлэх**

5.1.Сумын Засаг даргын шагналаар шагнуулах санаачлагыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олноос гаргана.

5.2.Сумын Засаг даргын “Хүндэт жуух” бичигт болзол хангасан нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ.

- 1.Байгууллагын эрх бүхий албан тушаалтны хүсэлт бүхий албан бичиг
- 2.Анкет /шагналын маягтаар, зураг заавал байх/
- 3.Ажил байдлын тодорхойлт /сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлт/
- 4.Иргэний үнэмлэхийн хуулбар
- 5.Хамт олны хурлын тэмдэглэл

5.3.Сумын “Хөдөлмөрийн аварга”-д болзол хангасан нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ.

- 1.Анкет /шагналын маягтаар, зураг заавал байх/
- 2.Ажил байдлын тодорхойлт /сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлт/
- 3.Улсад нийт 10 жил ажилласан байх
- 4.Хамт олны хурлын тэмдэглэл
- 5.Татварын өр зээлгүй болохыг гэрчилсэн баримт бичиг /төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хамааралтай/
- 6.Эрхэлсэн ажилдаа шинэ санаачилга, бүтээл гарган, түүнийг хэрэгжүүлснээр сум, орон нутгийн хэмжээнд ямар үр дүнд хүрснийг баримтаар дурьдах.

7.Дэвшүүлж байгаа номинацийг тодорхой бичиж, байгууллагын эрх бүхий албан тушаалтны хүсэлт бүхий албан бичиг

5.4.Хөдөлмөрийн аваргаар шалгаруулах байгууллага, ажилтны саналыг дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлэх.

5.5.Шагналын тодорхойлолтыг сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

5.6.Хугацаа хоцроож ирүүлсэн материалыг хүлээж авахгүй.

### **Зургаа.Шагнал олгох**

6.1.Шагналд зарцуулах хөрөнгийг сумын Засаг даргын нөөц сангаас гаргаж зарцуулна.

6.2.Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө гардуулна.

ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР